

ТАНИЛЦУУЛГА

Дэлхийн улс орнууд бүх салбарт инновац, өндөр технологийг хөгжүүлэхийг эрмэлзэн, түүнд оруулах хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байна. Тухайлбал АНУ-ын Жижиг бизнесийн захиргаанаас хэрэгжүүлдэг SBIR (Small Business Innovation Research) хөтөлбөрийг жил бүр 3 үе шаттайгаар хэрэгжүүлэн, 4000 орчим жижиг бизнесүүдэд 4 тэрбум ам.долларын дэмжлэгийг олгодог. Хөтөлбөрийн гол онцлог нь бизнес санаа, инновацын шийдлийг хөгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал, эхний үе шатанд бизнес санаа, инновацын шийдлийг дэмжихэд 50-275 мянган долларын санхүүжилт, хоёр дахь үе шатанд технологи хөгжүүлэлт, зүгшрүүлэлтэд 750-1.8 сая долларын санхүүжилт, гурав дахь үе шатанд тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, борлуулахад дэмждэг.

Манай улс нь 2012 онд Инновацын тухай хуулийг батлан хэрэгжүүлж ирсэн бөгөөд Глобал инновацын индексээр сүүлийн 5 жилийн хугацаанд дэлхийн 133 орноос 58-67 дугаар байранд эрэмбэлэгдэж байгаа нь мэдээллийн технологийн үйлдвэрлэл, үйлчилгээ, инновац шингэсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлэх асуудалд бодитой ахиц гарахгүй байгааг харуулж байна. Япон улсын Жайка байгууллага болон холбогдох бусад байгууллагатай хамтран хийсэн 2024 оны “Монгол Улсын гарааны бизнесийн экосистемийн суурь судалгаа”-ны тайланд эко системийг хөгжүүлэхэд салбарын хүний нөөцийг бүрдүүлэх (68%), эдийн засгийн тогтвортой орчин бий болгох (59%), инновацыг бодлогоор дэмжих (41%) зэрэг асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатайг онцолжээ.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 дүгээр сарын 07-ны өдрийн 224 дугаар тогтоолоор “Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”, “Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ыг баталсан нь санхүүжилт шаардлагатай инновацын төслүүдийг сонгон шалгаруулах, шалгарсан төслүүдэд санхүүжилт олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

Инновацын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14-т “инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журмыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж, мөн дээрх журмын хэрэгжилтийн хангах зорилгоор “Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам”-ыг боловсрууллаа. Журмын төсөлд дараах гол зохицуулалтуудыг оруулсан. Үүнд:

- Мэргэжлийн шинжээчид тавигдах шаардлага;
- Мэргэжлийн шинжээчийн эрх үүрэг;
- Сонгон шалгаруулалтад оролцож буй инновацын төслүүдэд үнэлгээ, дүгнэлт өгөх шалгуур, үнэлгээний онооны интервал;
- Төслийг үнэлэхдээ 1 шинжээч бүхэлд нь үнэлгээ өгөх байдлаас зайлсхийж, нэг шинжээч төсөл бүрийн 1 шалгуурыг үнэлэх байдлаар тусгасан.

Мөн мэргэжлийн шинжээчдийг бүртгэх, ажиллуулах үйл ажиллагааг Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ зохион байгуулахаар тусгасан ба тус байгууллагын чиг үүргийг нарийн тодорхойлж өгсөн.

Инновацын төслийн бүтээгдэхүүнд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах шалгуур үзүүлэлтийг “Европын Комиссын Хоризон Европ” байгууллага, НҮБ-ын Хөгжлийн

хөтөлбөр, Дэлхийн Банкны инновацын сан зэрэг нийтлэг хэрэглэдэг суурь үзүүлэлтийг жишиг болгон авсан.

Инновацын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14-д тус яамны эрх үүрэгт “инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журмыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах” гэж заасны дагуу “Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам”-ын төслийн боловсруулан танилцуулж байна.

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ТУШААЛ

2026 оны ... сарын ... -ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын яамны эрхзүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Инновацын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Цэнгүүнжав)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Цагаанхүү)-т тус тус үүрэг болгосугай.

Ч.НОМИН

ИННОВАЦЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААР ДҮГНЭЛТ ГАРГАХ, МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧДИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Инновацын тухай хуулийн 15.2-т заасны дагуу инновацын төслийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчийг /цаашид “Шинжээч” гэх/ бүртгэх, ажиллуулах болон түүнтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2.Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах мэргэжлийн шинжээчдийг бүртгэх, ажиллуулах үйл ажиллагааг Мэдээлэл, технологийн үндэсний парк ТӨААТҮГ /цаашид “Парк” гэх/ зохион байгуулна.

1.3.Шинжээч нь инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргахдаа хууль дээдлэх, хараат бус байх, төрийн болон байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг хадгалах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан ажиллана.

Хоёр. Шинжээч бүртгэх, томилох

2.1.Шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1.тухайн салбар, чиглэлээр мэргэшсэн магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх (тухайн чиглэлээр мэргэшсэн мэдлэгээ баталгаажуулсан холбогдох эрдмийн зэрэг, гэрчилгээ эсхүл түүнтэй адилтгах үнэмлэхтэй нэр дэвшигч нь шинжээчээр сонгогдоход давуу тал болно);

2.1.2.тухайн салбар, чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;

2.1.3.төрийн жинхэнэ албан хаагч биш байх.

2.2.Бүртгэлийг энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан асуулгын дагуу цахим хэлбэрээр хүлээн авч энэхүү журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан шинжээчдийн жагсаалтыг бүрдүүлнэ.

2.3. Шинжээчийг энэ журмын 5.1-нд заасан мэдээллийн сан эсвэл Шинжлэх ухаан технологийн санд байрлах шинжээчдийн мэдээллийн сангаас сонгон ажиллуулна.

2.4.Инновацийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах шинжээчийн баг нь 3 болон түүнээс дээш шинжээчтэй байх ба багийн бүрэлдэхүүнийг Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталгаажуулна.

Гурав. Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах

3.1.Шинжээч нь инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргахдаа Инновацын тухай хууль, Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам” болон энэхүү журмыг мөрдөнө.

3.2.Шинжээч инновацын төсөлтэй танилцахаас өмнө ашиг ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг Парк-т гаргаж өгнө.

3.3.Шинжээч дүгнэлт гаргахдаа тухайн төслийн өөрт хуваарилагдсан шалгуур үзүүлэлтийг үнэлэн 0-5 хүртэл онооны өгнө. Үүнд:

3.3.1."5 оноо" - Маш сайн;

3.3.2."4 оноо" - Сайн;

3.3.3."3 оноо" - Дундаж;

3.3.4."2 оноо" - Муу;

3.3.5."0-1 оноо" –Маш муу.

3.4.Инновацын бүтээгдэхүүний нийт оноог гаргахдаа шинжээчдийн үнэлгээг хувийн жинтэй нь уялдуулан тооцож нэгтгэн, төслүүдийг онооны дарааллаар эрэмбэлнэ.

Дөрөв.Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

4.1. Инновацын төслийг хүлээн авч, Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ын 3.3-т заасан шаардлагыг хангасан төсөлд шинжээчийн дүгнэлт гаргуулна.

4.2.Энэ журмын 4.1-д заасан төсөлд шинжээчийн дүгнэлт гаргуулах үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлийг холбогдох байгууллагад (Парк)-д өгнө.

4.3.Энэ журмын 3.4-д заасан төслүүдээс тухайн жилийн төсөвт багтаан эхэнд эрэмбэлэгдсэн төслүүдийг шалгаруулж гэрээ байгуулан, санхүүжилт олгоно.

4.4.Энэ журмын 2.4-т заасан шинжээчтэй гэрээ байгуулан, энэ журмын 5.6-т заасныг үндэслэн ажлын хөлс олгоно.

4.5.Ажлын хөлсийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан өмнөх улирлын аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын дундаж цалингийн нэг ажлын өдрийн цалинтай тэнцэх хэмжээний хөлсийг шинжээчийн ажлын хөлсөнд хүн өдрөөр тооцож олгоно.

Тав. Паркийн чиг үүрэг

5.1.Парк нь энэ журмын 2.1-д заасан шаардлага хангасан шинжээчийг бүртгэх, мэдээллийн сан үүсгэх үйл ажиллагааг зохион байгуулна.

5.2.Энэ журмын 2.2-т заасан шинжээчийн жагсаалтыг үүсгэн Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.3. Энэ журмын 2.4-т заасан баталгаажсан шинжээчдэд хэрхэн ажиллах талаар арга зүйн зөвлөгөөг өгнө.

5.4.Парк нь шинжээчийн дүгнэлт гаргахтай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.4.1.инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах төслүүдийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор энэ журмын 2.4-т заасан шинжээчдийн багийг ажиллуулж дүгнэлт гаргуулна.

5.4.2.шаардлагатай тохиолдолд инновац, хөрөнгө оруулалт болон бусад чиглэлээр нарийн мэргэшсэн эрдэмтэн, судлаачдыг урьж зөвлөгөө авах;

5.4.3.инновацын төслийг хувийн ашиг сонирхол болон бусад байдлаар ашиглахгүй байх;

5.4.4.инновацын төслийн бичиг баримтын бүрэн бүтэн байдлыг хариуцах.

5.5.Шинжээчийн дүгнэлт гарснаас хойш ажлын 2 өдрийн дотор энэ журмын 3.4-д заасны дагуу төслүүдийг эрэмбэлж, Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.6.Шинжээчдийн ажилласан цагийг тооцож, Өндөр технологи, үндэсний инновацыг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.7.Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, түүнтэй холбоотой баримт материалыг холбогдох журмын дагуу архив үүсгэн хадгална.

5.8. Шинжээчдийн багийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх.

Зургаа.Шинжээчийн чиг үүрэг

6.2.Шинжээч нь дараах эрх эдэлнэ:

6.2.1.үнэлгээ хийж дүгнэлт гаргахад шаардлагатай нэмэлт баримт бичгийг Паркаар дамжуулан холбогдох байгууллагаас гаргуулах;

6.2.3.шинжээчээр ажилласан ажлын хөлс авах.

6.3.Шинжээч дараах үүрэг хүлээнэ:

6.3.1. зах зээлийн боломж, төсөл хэрэгжүүлэгчийн дотоод уялдаа холбоог хангасан байдлыг харгалзан үндэслэл бүхий нотолгоонд суурилсан дүгнэлт гарган энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтад оноо өгч, дүгнэлтийг хавсаргах;

6.3.2.гаргасан дүгнэлтийнхээ үнэн зөвийг хариуцах;

6.3.3.шинжээчээр ажиллах үедээ олж мэдсэн байгууллага, хувь хүн, инновацын төслийн мэдээллийг хувийн ашиг сонирхол болон бусад байдлаар ашиглахгүй байх;

6.3.4.нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд дүгнэлт гаргахаас татгалзах.

6.4.Шинжээч энэ журмын 1.3-т заасан зарчмыг баримтлаагүйгээс гарах үр дагаврыг өөрөө хариуцах ба холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Долоо. Бусад

7.1.Инновацын төслийн шалгаруулалтад оролцогч нь хөндлөнгийн шинжээчийн үнэлгээ, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхөө илэрхийлж сонгон шалгаруулалтад оролцоно.

7.2.Аливаа маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

---oOo---

Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах,
мэргэжлийн шинжээчдийн ажиллах журмын нэгдүгээр хавсралт

**Инновацын төслийн бүтээгдэхүүнд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах
шинжээчийн бүртгэлийн хүснэгт**

№	Асуулт	Мэдээлэл
1.	Овог, нэр	
2.	Регистрийн дугаар	
3.	Татвар төлөгчийн дугаар	
4.	Харилцах дансны дугаар	
5.	Байнгын оршин суугаа хаяг	
6.	Холбоо барих утасны дугаар	
7.	И-мэйл хаяг	
8.	Мэргэжил, боловсролын зэрэг	
9.	Мэргэшил /3 хүртэлх/	
10.	Тухайн салбар, чиглэлээр ажилласан жил	
11.	Ажил эрхлэлт, ажлын туршлага /8-аас дээш жил/	
12.	Одоо эрхэлж буй ажил	
13.	Тодорхойлолт өгөх хүний нэр, албан тушаал, холбоо барих утасны дугаар	
14.	Бусад мэдээлэл /эрдмийн зэрэг цол, үнэмлэх, гэрчилгээ /	

Жич: Дээрх мэдээллийн үнэн зөв байдлыг илэрхийлэх нотлох баримтыг хавсаргана.

Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах,
 мэргэжлийн шинжээчдийн ажиллах журмын хоёрдугаар хавсралт

Инновацын төслийн бүтээгдэхүүнд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах хуудас

№	Шалгуур үзүүлэлт	Эзлэх жин	Үнэлгээ /0-5 оноо/	Оноо
1	Шинийг санаачилсан байдал - технологийн боломж - шинжлэх ухааны багтаамж	15%		
2	Нийгэм, эдийн засгийн үр ашиг - өрсөлдөх чадвар - тогтвортой байдал ба өргөжүүлэх боломж - эрсдэлийн үнэлгээ	15%		
3	Оюуны өмч, хууль эрх зүйн нийцэл - бүтээгдэхүүний оюуны өмч эсхүл давтагдаагүй байдал - нийгмийн сайн сайхны эсрэг чиглээгүй байх	10%		
4	Зах зээлийн боломж, цар хүрээ - нийгэм, эдийн засгийн хэрэгцээ - асуудал шийдвэрлэх чадамж - маркетинг болон бизнес төлөвлөгөө, зах зээлд гаргах боломжит хуваарь	20%		
5	Технологийн хэрэгжих боломж - бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргаж, технологийн туршилт, зүгшрүүлэлт хийсэн байдал	20%		
6	Хүний нөөцийн чадавх ба туршлага - төслийг амжилттай хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавхтай байх	10%		
7	Санхүүгийн чадавх, өртөг төсөв - санхүүгийн чадавхтай, аливаа хэлбэрийн хугацаа хэтэрсэн санхүүгийн болон хөрөнгийн өр төлбөргүй - үлдсэн санхүүжилтийг бусад эх үүсвэр (өөрийн хөрөнгө, банк, хөрөнгө оруулалтын сан, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт)-ээс бүрдүүлсэн байх	10%		
	Нийлбэр оноо	100%		

Жич: Программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн хувьд 5 дугаар шалгуур үзүүлэлтийн бүтээгдэхүүн, үйлчилгээний анхдагч загварыг гаргасан байдлыг үнэлнэ.

Баталгаажуулалт: